

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2022 /7/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2022 он

Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 7035 9826
Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 7035 8505
Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитор: Л.Баасандорж
Утас: 99055703
Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗГНХ	Засгийн Газрын Нөөц Хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НҮА	Нийтлэг үйлчилгээний алба
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № *47*

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА
Ц.ОДГЭРЭЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол улс 2021 оны төсвийн жилд хэмнэлтийн горимд шилжүүлэх Засгийн газрын тогтоол гарсаар байтал энэ оны хэмнэгдсэн цалингийн зардлаас ажилтан албан хаагчдад 17,321.4 мянган төгрөгийн урамшуулал цалинд, 1,040.0 мянган төгрөгийн шагналыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас, нийт 18,361.4 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүсэж болох зардлууд олгогдсон, тайлант хугацаанд 1,752.5 литр шатахууныг 3,051.0 мянган төгрөгөөр худалдан авч 6,757 км замыг туулахад зарцуулсан бөгөөд нормоос 1,012.62 км-ээр буюу нийт дүнгээр 1,762.9 мянган төгрөгийн шатахууныг

нормоос хэтрүүлэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын 1.3 дахь заалт ". . . цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, . . .", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал "Жишиг норм батлах тухай"-ын хавсралт 1 "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", хавсралт 2 "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд"-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,511,808.00	42,760,785.84
33	АВЛАГА	-	248,977.84
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	2,192.84
335	Бусад авлага	-	246,785.00
3351	Байгууллагаас авах авлага	-	246,785.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,511,808.00	42,511,808.00
351	Түүхий эд материал	35,842,308.00	35,842,308.00
35110	Тусгай зориулалттай материал	35,842,308.00	35,842,308.00
354	Хангамжийн материал	6,669,500.00	6,669,500.00
35410	Бичиг хэргийн материал	72,000.00	72,000.00
35420	Аж ахуйн материал	1,187,800.00	1,187,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	640,000.00	640,000.00
35450	Барилгын засварын материал	3,677,700.00	3,677,700.00
35470	Бусад хангамжийн материал	1,092,000.00	1,092,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,502,342,521.84	1,477,328,790.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,502,342,521.84	1,477,328,790.20
392	Биет хөрөнгө	1,486,302,521.84	1,461,288,790.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,508,481,908.00	1,508,481,908.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,435,683.35)	(75,655,042.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,999,700.00	38,999,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,041,654.16)	(18,166,616.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,965,140.00	13,607,640.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,933,057.72)	(6,950,201.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,567,495.20	4,419,615.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,301,326.13)	(3,448,212.21)
393	Биет бус хөрөнгө	16,040,000.00	16,040,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,040,000.00	16,040,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,544,854,329.84	1,520,089,576.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,544,854,329.84	1,520,089,576.04
51	Засгийн газрын хувь оролцоо	1,544,854,329.84	1,520,089,576.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,040,000.00	16,040,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,289,067,827.20	1,264,303,073.40
51210	Өмнөх үеийн үр дүн	1,289,067,827.20	1,289,067,827.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	(24,764,753.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,746,502.64	239,746,502.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,544,854,329.84	1,520,089,576.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	688,438,198.00	565,039,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,514,098.00	4,803,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	93,514,098.00	4,803,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	93,514,098.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93,514,098.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/		4,803,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	594,924,100.00	560,235,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,688,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,188,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	594,924,100.00	555,547,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	594,924,100.00	555,547,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	679,919,378.05	591,586,153.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	679,919,378.05	591,586,153.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622,735,172.99	553,080,088.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,575,014.00	424,472,548.00
210101	Үндсэн цалин	397,950,125.00	380,159,154.00
210102	Нэмэгдэл	4,626,832.00	3,479,216.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,288,400.00	23,512,800.00
210104	Урамшуулал	10,709,657.00	17,321,378.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,666,479.10	55,324,805.44
210201	Тэтгэврийн даатгал	37,624,246.40	38,937,673.95
210202	Тэтгэмжийн даатгал	4,361,405.72	4,228,453.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,489,124.59	3,382,762.74
210204	Ажилгүйдлийн даатгал	835,609.31	797,810.48
210205	Эрүүл мэндийн даатгал	8,356,093.08	7,978,104.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,152,246.84	22,915,471.32
210301	Гэрэл, цахилгаан	2,950,758.00	3,317,215.00
210302	Түлш, халаалт	16,551,488.84	14,066,256.32
210303	Цэвэр, бохир ус	2,650,000.00	5,532,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,228,275.00	13,029,692.21
210401	Бичиг хэрэг	1,331,625.00	1,213,630.00
210402	Тээвэр, шатахуун	3,052,000.00	3,051,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,118,800.00	1,023,862.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	256,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,469,850.00	7,485,200.00
2105	Нормативт зардал	1,080,000.00	-
210502	Хоол, хүнс	1,080,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,439,400.00	5,904,200.00
210604	Урсгал засвар	62,439,400.00	5,904,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,310,490.00	1,616,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,340.00	180,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,750.00	134,050.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	-	240,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,283,268.05	29,817,231.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,283,268.05	29,817,231.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,184,205.06	38,506,065.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,888,500.00	16,945,822.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,018,500.00	10,998,722.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,870,000.00	5,947,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,295,705.06	19,778,243.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,295,705.06	19,778,243.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,518,819.95	(24,764,753.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,518,819.95	(24,764,753.80)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	607,436,790.00	587,262,564.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	607,436,790.00	587,262,564.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,470,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,970,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	594,924,100.00	555,547,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	594,924,100.00	555,547,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,512,690.00	25,244,664.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,512,690.00	25,244,664.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	607,136,800.00	587,262,564.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	607,136,800.00	587,262,564.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	536,359,904.94	523,511,834.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,575,014.00	424,948,429.00
210101	Үндсэн цалин	281,630,995.35	272,273,086.00
210102	Нэмэгдэл	120,520,074.62	128,009,419.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,423,944.03	24,665,924.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,666,479.10	54,851,117.28
210201	Тэтгэврийн даатгал	36,545,038.85	38,201,199.92
210202	Тэтгэмжийн даатгал	4,530,090.56	4,411,517.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,624,072.45	3,408,339.04
210204	Ажилгүйдлийн даатгал	906,018.11	826,385.23
210205	Эрүүл мэндийн даатгал	9,061,259.13	8,003,675.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,152,246.84	23,162,256.32
210301	Гэрэл, цахилгаан	2,950,758.00	3,564,000.00
210302	Түлш, халаалт	16,551,488.84	14,066,256.32
210303	Цэвэр, бохир ус	2,650,000.00	5,532,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,216,275.00	12,986,692.21
210401	Бичиг хэрэг	1,139,625.00	1,158,630.00
210402	Тээвэр, шатахуун	3,052,000.00	3,051,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,118,800.00	1,023,862.21
210404	Ном, хэвлэл	90,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	256,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,559,850.00	7,497,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,439,400.00	5,947,200.00
210604	Урсгал засвар	6,439,400.00	5,947,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,310,490.00	1,616,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	245,340.00	180,090.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,750.00	134,050.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	-	240,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,776,895.06	63,750,729.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,481,190.00	43,972,486.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	12,512,690.00	27,026,664.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,018,500.00	10,998,722.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,950,000.00	5,947,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,295,705.06	19,778,243.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,295,705.06	19,778,243.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	299,990.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
22	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	299,990.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	299,990.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	299,990.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(299,990.00)	0.00
8	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,040,000.00	239,746,502.64	1,280,549,007.25	1,536,335,509.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,040,000.00	239,746,502.64	1,280,549,007.25	1,536,335,509.89
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	8,518,819.95	8,518,819.95
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,040,000.00	239,746,502.64	1,289,067,827.20	1,544,854,329.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,040,000.00	239,746,502.64	1,289,067,827.20	1,544,854,329.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(24,764,753.80)	(24,764,753.80)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	16,040,000.00	239,746,502.64	1,264,303,073.40	1,520,089,576.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %-аар
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	555,547,900.00	535,769,656.81	19,778,243.19	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,547,900.00	535,769,656.81	19,778,243.19	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,121,000.00	518,823,834.81	19,297,165.19	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,045,700.00	424,948,429.00	14,097,271.00	96.8
210101	Үндсэн цалин	298,371,400.00	272,273,086.00	26,098,314.00	91.3
210102	Нэмэгдэл	103,680,700.00	128,009,419.00	(24,328,719.00)	123.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,993,600.00	24,665,924.00	12,327,676.00	66.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,271,200.00	54,851,117.28	4,420,082.72	92.5
210201	Тэтгэврийн даатгал	41,709,300.00	38,201,199.92	3,508,100.08	91.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,390,500.00	4,411,517.33	(21,017.33)	100.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,512,400.00	3,408,339.04	104,060.96	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	878,100.00	826,385.23	51,714.77	94.1
210205	Эрүүл мэндийн даатгал	8,780,900.00	8,003,675.76	777,224.24	91.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,164,300.00	23,162,256.32	2,043.68	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,564,000.00	3,564,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	13,840,300.00	14,066,256.32	(225,956.32)	101.6
210303	Цэвэр, бохир ус	5,760,000.00	5,532,000.00	228,000.00	96.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,900,400.00	12,248,692.21	651,707.79	94.9
210401	Бичиг хэрэг	1,140,000.00	1,158,630.00	(18,630.00)	101.6
210402	Тээвэр, шатахуун	3,052,000.00	3,051,000.00	1,000.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,648,400.00	1,023,862.21	624,537.79	62.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	256,000.00	44,000.00	85.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,760,000.00	6,759,200.00	800.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,997,200.00	2,800.00	99.9
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,997,200.00	2,800.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,739,400.00	1,616,140.00	123,260.00	92.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	200,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	243,400.00	180,090.00	63,310.00	74.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,000.00	134,050.00	59,950.00	69.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	240,600.00	240,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,426,900.00	16,945,822.00	481,078.00	97.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,426,900.00	16,945,822.00	481,078.00	97.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,476,900.00	10,998,722.00	478,178.00	95.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,950,000.00	5,947,100.00	2,900.00	100.0
1320	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	555,547,900.00	535,769,656.81	19,778,243.19	96.4
132001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	555,547,900.00	535,769,656.81	19,778,243.19	96.4
132001	Орон нутгийн төсвөөс	555,547,900.00	535,769,656.81	19,778,243.19	96.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.00	0.00	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	43.00	43.00	0.00	0.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.00	0.00
620003	Үйлчлэх ажилтан	38.00	38.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	2021.12.31
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,688,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,688,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,688,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	738,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	738,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,950,000.00
210604	Урсгал засвар	3,950,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,688,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,688,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,188,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалин хөлсний тооцоолол, цалингийн урамшуулал, шагнал, шатахууны зарцуулалт ба хэмжилт, төсвийн зарцуулалт, хөрөнгийн ангилал, үндсэн хөрөнгийн элэгдэл, авлага өглөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Баасандорж гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны чиг үүрэг нь Орхон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэрэгжүүлэгч агентлаг болон аймгийн ЗДТГ-ын хэлтэс, алба, төсвийн байгууллагуудад үйлчилгээ үзүүлж, тэдгээр хэлтэс албадыг төрийн үйл ажиллагаагаа хэвийн жигд явуулах нөхцөл бололцоогоор хангах явдал юм. Нийтлэг үйлчилгээний алба нь Нутгийн удирдлагын ордон, Захиргааны 3 болон 4-р байр, төрийн үйлчилгээний нэгдсэн төв байр, аймгийн ЗДТГ-ын Спорт заал гэсэн үндсэн 5 объектын харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцаж, цахилгаан болон сантехникийн эвдрэл гэмтэл гаргахгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын дотоод хяналт, шалгалтын комисс нь даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулагдсан. Тайлант хугацаанд дотоод хяналт, шалгалтын комисс нь ХАБЭА, үйлчилгээний хяналт, шилэн данс, санхүүгийн ил тод байдал, цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа,

ариутгал, бараа материалын ашиглалт, цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, нярвын анхан шатны баримт хөтлөлт, худалдан авч буй материалын чанар, тушаал, шийдвэр, хууль тогтоомжийн хэрэгжилт зэрэг нийт 10 чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөж, гүйцэтгэсэн байна. Дотоод хяналт, шалгалтаар ямар нэгэн зөрчил илрээгүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Түүнчлэн Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт 2021 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан бөгөөд уг шалгалтаар 2 ажилтанд төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 5%-аар илүү олгосон, шагнал урамшууллыг хамт олноор хэлэлцүүлэлгүй олгосон, цалингийн шатлал ялгаварлалтай тогтоогүй зэрэг алдаа зөрчил гарсныг залруулан ажиллаж, зөвлөмжийн хэрэгжилтийн 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 48 тоот албан бичгээр хүргүүлж ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 555,547.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,110.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,777.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд төсвийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөлтийн үед сонгон авсан хувь хэмжээ, гүйцэтгэл тооцох хувийг ашиглан материаллаг байдлыг шинэчлэн тогтооход 2.8%-аар буюу 301.8 мянган төгрөгөөр буурсан тул АДБОУС-д тодорхойлсны дагуу материаллаг байдлыг 7,566.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,764.7 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Үзүүлэлт	Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Авлага	-	249.0	249.0	100
Урьдчилгаа	-	-	-	-
Бараа материал	42,511.8	42,511.8	-	0
Үндсэн хөрөнгө	1,502,342.5	1,477,328.8	(25,013.7)	(1.7)
Нийт хөрөнгө	1,544,854.3	1,520,089.6	24,764.7	(1.6)
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо	1,544,854.3	1,520,089.6	24,764.7	(1.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмч	1,544,854.3	1,520,089.6	24,764.7	(1.6)

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн 2 данстай болно.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210051023 тоот дансаар 581,968.6 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Мөнгөн орлогын 1,782.0 мянган төгрөг нь нэмэлт

санхүүжилтийн данснаас, 555,547.9 мянган төгрөг нь орон нутгийн төсвийн санхүүжилт, 3,925.8 мянган төгрөг нь нийгмийн даатгалын байгууллагаас олгогдох ХЧТА-ны тэтгэмж, 20,712.8 мянган төгрөг нь нэр данс зөрүүтэй ажил гүйлгээний орлого байна. Уг мөнгөн орлогоос 3,925.8 мянган төгрөгийн ХЧТА-ны тэтгэмжийн мөнгийг бүрэн олгосон ба нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлэгдэж орж ирсэн 1,782.0 мянган төгрөгийн орлогыг Эрдэнэт санд төвлөрүүлсэн байна. Түүнчлэн мөнгөн орлогоос 556,482.5 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 19,778.2 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн 100210051426 тоот дансаар 6470.0 мянган төгрөгийн орлого орж зарцуулагджээ. Уг орлого нь ЗДНХ-өөс хуваарилсан 3,500.0 мянган төгрөг, байгууллагын төлбөртэй үйлчилгээнээс орсон 2,970.0 мянган төгрөгийн орлогоос бүрдэж байна. Уг орлогоос 4,688.0 мянган төгрөгийг бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулж, үлдсэн 1,782.0 мянган төгрөгийн үндсэн харилцах дансанд шилжүүлж, Эрдэнэт сан руу төвлөрүүлсэн байна.

Тайлант оны эхэнд тус байгууллага нь авлагагүй байсан ба 2021 онд 5,956.8 мянга төгрөгийн авлага үүсэж, үүнээс 5,707.8 мянган төгрөгийн авлага цуглуулагдсанаар 249.0 мянган төгрөгийн авлагатай үлдсэн байна.

Харин тайлант онд 79,090.3 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгогдож буцаан суутгагдсанаар урьдчилж гарсан зардал үлдэгдэлгүй толилуулагдсан байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос өсөж буураагүй боловч дараах хөдөлгөөн гарчээ. Үүнд:

- Тусгай зориулалтын болон аж ахуйн материалд огт хөдөлгөөн гараагүй байна.
- Бичиг хэргийн материал тайлант онд 1,173.6 мянган төгрөгөөр худалдан авч, бүгдийг нь бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.
- Сэлбэг хэрэгсэл тайлант онд 113.0 мянган төгрөгөөр худалдан авч, бүгдийг нь урсгал засварын зардалд зарцуулсан байна.
- 3,051.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч, бүгдийг нь тээвэр, шатахууны зардал зарцуулсан байна.
- Тайлант онд 7,482.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материал худалдан авч, 40.0 мянган төгрөгийн материалыг бичиг хэргийн зардалд, үлдсэнийг бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлсийн зардалд зарцуулжээ.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1.7%-аар буюу 25,013.7 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд дараах хөрөнгүүдийн хөдөлгөөн, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

- Барилга, байгууламжийн анхны өртөгт өөрчлөлт гараагүй бөгөөд тайлант онд уг бүлэг хөрөнгөд 25,219.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар хуримтлагдсан элэгдэл 50%-аар нэмэгдэж, дансны үнийг 1.7%-аар бууруулсан байна.
- Тээврийн хэрэгслийн анхны өртөгт өөрчлөлт гараагүй бөгөөд тайлант онд уг бүлэг хөрөнгөд 3,125.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар хуримтлагдсан элэгдэл 20.8%-аар нэмэгдэж, дансны үнийг 13%-аар бууруулсан байна.
- Тайлант онд 2,865.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн байгууллагуудад зөөврийн компьютер худалдаж авах ОР-121/2021 тоот гэрээний дагуу, Орхон аймгийн Засаг даргын А/179 дугаар бүхий захирамжийн дагуу 2,280.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 342.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хяналтын камерын иж бүрэн тоног төхөөрөмж зэргийг тус тус хүлээн авч орлогод авсан байна. Түүнчлэн Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/165 дугаар захирамж "Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх тухай"-ийн дагуу ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 503.0 мянган төгрөгийн 4 нэр төрлийн тоног төхөөрөмжийг акталсан байна. Уг бүлэг хөрөнгөд тайлант онд 1,178.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргийн үр нөлөөгөөр анхны өртөг 4,642.5 мянган төгрөгөөр буюу 51.8%-аар, хуримтлагдсан элэгдэл 17.1%-аар буюу 1,017.1 мянган төгрөгөөр, дансны үнэ 3,625.4 мянган төгрөгөөр буюу 119.6%-аар тус тус өссөн байна.
- Тайлант онд тавилга, эд хогшил бүлэг хөрөнгөтэй холбоотой худалдан авалт хийгдээгүй, харин Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/165 дугаар

захирамж “Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх тухай”-ийн дагуу ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 147.9 мянган төгрөгийн 3 нэр төрлийн тавилга эд хогшлыг акталсан байна. Тайлант онд уг бүлэг хөрөнгөд 294.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргийн үр нөлөөгөөр анхны өртөг 3.2%-аар буюу 147.9 мянган төгрөгөөр буурч, хуримтлагдсан элэгдэл 4.4%-аар буюу 146.9 мянган төгрөгөөр өсөж, дансны үнэ 294.8 мянган төгрөгөөр буюу 23.3%-аар буурсан байна.

- Газар эзэмших эрхэд өөрчлөлт гараагүй байна.

Тайлант онд өр төлбөргүй ажиллаж, өр төлбөрийн данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна. 2021 онд цалингийн 444,662.0 мянган төгрөгийн, НДШ-ийн 105,468.5 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 26,386.5 мянган төгрөгийн, үйлдвэрчний эвлэлийн холбооны 4,228.4 мянган төгрөгийн, шуудан холбооны 1,023.9 мянган төгрөгийн, гэрэл цахилгааны 3,564.0 мянган төгрөгийн, түлш халаалтын 14,066.2 мянган төгрөгийн, цэвэр, бохир усны 5,532.0 мянган төгрөгийн, тээвэр шатахууны 3,051.0 мянган төгрөгийн, байгууллагад өгөх 32,819.1 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 21,509.5 мянган төгрөгийн өр төлбөрүүд үүсэж, бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 24,764.7 мянган төгрөгөөр буюу 1.6%-аар буурч 1,520,089.6 мянган төгрөг болжээ. Үүнд тайлант үеийн үр дүн 24,764.7 мянган төгрөгөөр буурснаар хуримтлагдсан үр дүн буурсан нь нөлөөлжээ. Засгийн газрын оруулсан капитал, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өөрчлөлт ороогүй байна.

Орлогын нэр төрөл	Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020	2021	Өөрчлөлт	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,924.1	555,547.9	(39,376.2)	(6.6)
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,500.0	3,500.0	100.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93,514.1	4,803.5	(88,710.6)	(94.9)
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,188.0	1,188.0	100.0
Нийт орлого	688,438.2	565,039.4	(123,398.8)	(17.9)

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 123,398.8 мянган төгрөгөөр буюу 17.9%-аар буурсан байна. Үүнд, урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 39,376.2 мянган төгрөгөөр буюу 6.6%-аар, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 88,710.6 мянган төгрөг буюу 94.9%-аар буурч, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,500.0 мянган төгрөгөөр буюу 100%, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,188.0 мянган төгрөгөөр буюу 100%-аар тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүнийг орлогын нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 6.6%-аар буюу 39,376.2 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 тоот тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”-ын дагуу урсгал санхүүжилт өмнөх оноос буурч батлагдсантай холбоотой байна.
- Өмнөх онд тус байгууллага нь төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого олж байгаагүй бол энэ жил 1,188.0 мянган төгрөгийн орлого олсон байна.
- Тайлант онд ЗДНХ-өөс 3,500.0 мянган төгрөг хуваарилагдсан байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого тайлант онд өмнөх оноос 88,710.6 мянган төгрөгөөр буюу 94.9%-аар буурсан дараах нөлөөтэй байна. Үүнд:

Санхүүжилтийн эх үүсвэр	Орлогын төрөл	Төрөл	Хүснэгт 3. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын үзүүлэлт /мянган төгрөг/	
			2020	2021
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Үндсэн хөрөнгө	Машин тоног төхөөрөмж		2,865.5
		Машин тоног төхөөрөмж		1,938.0
		Тээврийн хэрэгсэл	24,999.7	
	Бараа материал	Тусгай зориулалтын материал	12,314.4	
		Бусад хангамжийн материал	56,200.0	
ДҮН			93,514.1	4,803.5

- Энэ онд төрийн захиргааны байгууллагуудын завсар үйлчилгээг хийхтэй холбоотойгоор ЗДНХ-өөс 3,500.0 мянган төгрөгийг хуваарилж олгосон байна.

Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020	2021	Өөрчлөлт	Хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	679,919.4	589,804.2	(90,115.2)	-13.3
УРСГАЛ ЗАРДАЛ	679,919.4	589,804.2	(90,115.2)	-13.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622,735.2	553,080.1	(69,655.1)	-11.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,575.0	424,472.5	(12,102.5)	-2.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,666.5	55,324.8	658.3	1.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,152.2	22,915.5	763.2	3.4
Хангамж, бараа материалын зардал	15,228.3	13,029.7	(2,198.6)	-14.4
Нормативт зардал	1,080.0	-	(1,080.0)	-100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	62,439.4	5,904.2	(56,535.2)	-90.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,310.5	1,616.1	305.7	23.3
Бараа үйлчилгээний бусад зардал	29,283.3	29,817.2	534.0	1.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,184.2	36,724.1	(20,460.1)	-35.8
Бусад урсгал шилжүүлэг	38,888.5	16,945.8	(21,942.7)	-56.4
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,295.7	19,778.2	1,482.5	8.1

Нийт зардал өмнөх оноос 13.3%-аар буюу 90,115.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант он үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын бууралтад бараа, ажил үйлчилгээний зардлын бууралт 11.2%-аар буюу 69,655.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 35.8%-аар буюу 20,460.1 мянган төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна. Үүнд:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд ажилчдын цалин хөлс 2.8%-аар буюу 12,102.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 14.4%-аар буюу 2,198.6 мянган төгрөгөөр, нормативт зардал 100%-аар буюу 1,080.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 90.5%-аар буюу 56,535.2 мянган төгрөгөөр буурч НДШ-ийн зардал 1.2%-аар буюу 658.3 мянган төгрөгөөр, тогтмол зардал 3.4%-аар буюу 763.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 23.3%-аар буюу 305.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1.8%-аар буюу 534.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.
- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын бууралтад бусад урсгал шилжүүлэг өмнөх оноос 56.4% буюу 21,942.7 мянган төгрөгөөр буурч, орон нутгийн төсвийн төвлөрүүлэх урсгал шилжүүлэг өмнөх оноос 8.1%-аар буюу 1,482.5 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 24,764.7 мянган төгрөгөөр буюу 1.6%-аар буурсан нь тайлант оны үр дүнгийн бууралтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд суурилан өмнөх жилүүдэд уламжлагдан ирсэн төсвийн төсөл зохиох MS-Excel программд тулгуурласан маягт аргачлалын дагуу боловсруулж, байгууллагын даргад танилцуулан санал, зөвлөмжийг тусган эцэслэсний дараа төсвийн саналыг Төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд Орхон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэнд боловсруулж хүргүүлдэг бөгөөд уг төсвийн төсөл Орхон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэгдэн батлагдаж, Санхүү төрийн сангийн хэлтсээр дамжуулагдан байгууллагад хүргэгдэж ирдэг. Төсвийн төслийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан жил бүр шинэчлэн хүргүүлдэг боловч байгууллагын санал тэр бүр тусгагддаггүй, өмнөх жилийн төсвөөс материаллаг зөрүүгүй батлагдаж ирдэг байна.

Батлагдсан төсвийн зарлага болох 555,547.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр баталжээ. Тайлант хугацаанд Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны батлагдсан төсвийн хуваарьт бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн зүйлсийн зардлаас түлш, халаалтын зардалд 2,800.0 мянган төгрөгийг, даатгалын үйлчилгээний зардлаас газрын төлбөрт 240.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулах зохицуулалт 1 удаа хийгдсэн байна.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 555,547.9 мянган төгрөг болж төсвийн дүн өмнөх оны төлөвлөгөөнөөс 6.6%-аар буюу 39,376.2 мянган төгрөгөөр буурсан бол 2021 оны анхны батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна. Эдгээртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5 Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төсвийн төлөвлөлт			2020/2021 оны зөрүү	Хувь	2021 оны тодотгол зөрүү	Хувь
		2020 оны төсвийн төлөвлөгөө	2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө	2021 оны батлагдсан төлөвлөгөө				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,924.1	555,547.9	555,547.9	(39,376.2)	-6.6	-	0.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,955.6	538,121.0	538,121.0	(16,834.6)	-3.0	-	0.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444,045.7	439,045.7	439,045.7	(5,000.0)	-1.1	-	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,505.8	59,271.2	59,271.2	3,765.4	6.8	-	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,364.3	20,364.3	23,164.3	(6,200.0)	-21.1	2,800.0	13.7
2104	Хангамж, бараа материалын зардал	15,796.4	15,700.4	12,900.4	(2,896.0)	-18.3	(2,800.0)	-17.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000.0	2,000.0	2,000.0	(6,000.0)	-75.0	-	0.0
2107	Томилолт, зочны зардал	300.0	-	-	(300.0)	-100.0	-	-100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,343.4	1,739.4	1,739.4	396.0	29.5	-	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600.0	-	-	(600.0)	-100.0	-	-100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,968.5	17,426.9	17,426.9	(22,541.6)	-56.4	-	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,968.5	17,426.9	17,426.9	(22,541.6)	-56.4	-	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	594,924.1	555,547.9	555,547.9	(39,376.2)	-6.6	-	0.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	594,924.1	555,547.9	555,547.9	(39,376.2)	-6.6	-	0.0

Дээрх төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтөд үзүүлсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг тайлбарлан авч үзвэл дараах байдалтай байна. Тайлант онд батлагдсан төсөв өмнөх оноос НДШ-ийн зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал өсөж, бусад урсгал зардал буурч батлагдсан байна. Энэ нь 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 тоот тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ыг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой болно.

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, Ажил олгогчоос төлөх НДШ: Тайлант онд өмнөх оноос цалин хөлс 5,000.0 төгрөгөөр буюу 1.1%-аар буурч, НДШ-ийн зардал 3,765.4 мянган төгрөгөөр буюу 6.8%-аар өсөж батлагдсан байна. НДШ өссөн нь хуульд орсон өөрчлөлттэй холбоотой.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Өмнөх оноос 6,200.0 мянган төгрөгөөр буюу 21.1%-аар буурч, анхны төсвөөс 2,800.0 төгрөгөөр буюу 13.7%-аар өсөж батлагдсан байна. Анхны төсвийн өөрчлөлт нь төсөвт хийсэн зохицуулалттай холбоотой юм.
- Хангамж, бараа материалын зардал: Өмнөх оноос 6,000.0 мянган төгрөгөөр буюу 75%-аар буурч батлагдсан байна.
- Эд хогшил, урсгал засварын зардал: Өмнө оны батлагдсан төсвөөс 800.0 мянган төгрөгөөр буюу 78.3%-аар буурч батлагдсан байна.
- Томилолт, зочны зардал: Өмнөх оны төсвөөс 100%-аар буюу 300.0 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна.

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Өмнөх оноос 396.0 мянган төгрөгөөр буюу 29.5%-аар өсөж батлагджээ.
- Бусад бараа үйлчилгээний зардал: Өмнөх оны төсвөөс 100%-аар буюу 600.0 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна.
- Урсгал шилжүүлэг зардал: Өмнөх оны батлагдсан төсвөөс 22,541.6 мянган төгрөгөөр буурч батлагдсан бөгөөд энэ ажилчин тэтгэвэрт гарахтай холбоотой тэтгэмж буурсантай холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 555,547.9 мянган төгрөгийн төсөв баталж орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535,769.6 мянган төгрөг буюу 96.4% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	555,547.9	535,769.7	19,778.2	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,547.9	535,769.7	19,778.2	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,121.0	518,823.8	19,297.2	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,045.7	424,472.5	14,573.2	96.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,271.2	55,327.0	3,944.2	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,164.3	23,162.3	2.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,900.4	12,248.7	651.7	94.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000.0	1,997.2	2.8	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,739.4	1,616.1	123.3	92.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,426.9	16,945.8	481.1	97.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,426.9	16,945.8	481.1	97.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	555,547.9	535,769.7	19,778.2	96.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	555,547.9	535,769.7	19,778.2	96.4

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 14,573.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,944.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 651.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 2.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас 123.3 мянган төгрөг, бусад урсгал зардлаас 481.1 мянган төгрөг хэмнэж, батлагдсан төсвөөс орон нутгийн төсөвт 19,778.2 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 3,500.0 мянган төгрөгийг төрийн захиргааны байгууллагуудад урсгал засвар хийхэд зориулж санхүүжилт олгосон бол байгууллагын төлбөртэй ажил үйлчилгээний орлогоос 1,188.0 мянган төгрөг олж, нийт 4,688.0 мянган төгрөгийн мөнгө орлого олж, нэмэлт төсвөөс бага үнэтэй, түргэн элэгдэл эд зүйлс худалдан авахад 738.0 мянган төгрөгийг, урсгал засварт 3,950.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн дараа үеийн хэмжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 14,000.0 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 1 нэр төрлийн 1 ширхэг тээврийн хэрэгсэл, 4,312.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй 7 нэр төрлийн 7 ширхэг машин тоног төхөөрөмж, 1,629.4 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 7 нэр төрлийн 7 ширхэг тавилга эд хогшил зэрэг хөрөнгө байгууллагын хяналтад оршиж, ашиглагдсаар байна.

УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийн 44 дугаар параграф “хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг хянан магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино.”, 49 дүгээр параграф “Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллаг өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг”, 51 дүгээр параграф “хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харьяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ” гэж тус тус заажээ. Стандартын дээрх заалтуудаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэсэн хөрөнгийн ангид байгаа хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг ялгаатай үед тухайн ангид байгаа бүх хөрөнгийг дахин үнэлэхийг шаардаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 дугаарт “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасан байна.

Эдгээр стандарт болон хуулийн заалтуудад нийцүүлэн дээрх хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн ангиар нь дахин үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах бодит хэрэгцээ, шаардлага байгааг бүх шатны төсвийн захирагч нар анхаарах нь зүйтэй юм.

Энэ асуудалтай холбоотойгоор бидний дүгнэлт хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Бидний гүйцэтгэж буй санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал, толилуулгад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал тохиолдоогүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл, тайлант хугацаанд оруулбал зохих 121 мэдээллээс хугацаандаа оруулсан 109, хоцроож мэдээлсэн 12, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Шилэн дансны хэрэгжилтэд тайланд оны 1, 2, 3 дугаар улиралд Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалтыг зохион байгуулсан бөгөөд харгалзан 95%, 97.4%, 100%-тай дүгнэгдсэн байна.

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, “4.1.3 дахь заалт “*тогтсон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх*”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “*Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандарт тогтоох журам*”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь хугацаа хоцроож мэдээлсэн 12 мэдээллийг эс тооцвол Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтууд нийцсэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитын явцад бусад хууль тогтоомжийн хүрээнд хөндөгдөхүйц нийцлийн аудитын асуудал ажиглагдаагүй болно.

Тиймээс шилэн дансны хэрэгжилт болон энэхүү тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 38.1% хувьтай байна.

Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага	2	58,168.0	1	1,149.7	1	57,028.3	2
Зөвлөмж	2	34,018.5	1	34,018.5	-	-	-
Нийт дүн	2	92,196.5	2	35,168,2	1	57,028.3	38.1

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 61 тоот албан бичиг, 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 91 тоот алба бичгээр тус тус Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын ангилалтай холбоотой асуудал

Бид аудитаар тус байгууллагын бараа материалаарх хөрөнгийн үлдэгдэлд ажиглалт, шинжилгээний горим хэрэгжүүлэхэд хөрөнгүүдийн ангилал зөрүүтэй байна. Аудитын цаг хугацааны хязгаарлалтаас үүдэн уг алдаа нь залруулагдаагүй тул дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,213.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, материаллаг шинжтэй 20,124.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, материаллаг бус 7,089.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Орлогын дансны тайлагналтай холбоотой асуудал

Аудитаар нэмэлт төсвийн дансаар хүлээн авсан төлөвлөгдөөгүй түрээсийн орлого болох 2,970.0 мянган төгрөгийн 60% буюу 1,792.0 мянган төгрөг нь тухайн байгууллагад үл хүлээн зөвшөөрөгдөх, Эрдэнэт санд төвлөрүүлэгдэх орлого байна. Байгууллага уг орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд төсөвт байгууллагын хүрээнд бий болсон нэмэлт орлогоор хүлээн зөвшөөрч, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байсныг залруулж, тухайн байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаас орлого, зардлыг хасаж залруулсан болно.

Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Цалингийн зардлаас НДШ-ийн зардал руу 511.3 мянган төгрөгийг холбогдох тушаал шийдвэргүйгээр гүйлгэн зарцуулсныг 2022 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн 12 тоот албан бичгийг Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж залруулсан болно.

4.2 Төлбөрийн акт

Бидний гүйцэтгэсэн аудитаар горим, сорилоор тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналд төлбөрийн акт тогтоох түвшний материаллаг алдаа, зөрчил илэрхийлэгдээгүй болно.

4.3 Албан шаардлага

1. Цалин хөлсний урамшуулал, шагналтай холбоотой асуудал

Монгол улс 2021 оны төсвийн жилд хэмнэлтийн горимд шилжүүлэх Засгийн газрын тогтоол гарсаар байтал энэ оны хэмнэгдсэн цалингийн зардлаас ажилтан албан хаагчдад 17,321.4 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, 1,040.0 мянган төгрөгийн шагналыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас олгож, нийт 18,361.4 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүсэж болох зардлууд зарцуулагдсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын 1.3 дахь заалт “. . . цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, . . .” гэсэнтэй нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Тайлант хугацаанд 1,752.5 литр шатахууныг 3,051.0 мянган төгрөгөөр худалдан авч 6,757 км замыг туулахад зарцуулсан бөгөөд нормоос 1,012.62 км-ээр буюу нийт дүнгээр 1,762.9 мянган төгрөгийн шатахууныг нормоос хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал “Жишиг норм батлах тухай”-ын хавсралт 1 “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, хавсралт 2 “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн ангилалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материал оновчтой ангилагдаагүй, дэд ангилал үүсгэн бүртгээгүй байна. Тусгай зориулалтын материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүд бүртгэгдсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Журам батлах тухай”-ын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.16, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай”-ын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС 12 “Бараа материал”, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” зэрэг хууль эрх зүйн заалтууд болон стандартад нийцүүлэн хөрөнгийг дахин ангилах, дансны дэд ангилал үүсгэх

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ажилчдын цалин хөлсийг нийгмийн даатгалд дутуу тайлагнасангай холбоотой 80.5 мянган төгрөгийн НДШ дутуу тайлагнагдсан, мөнгөн гүйлгээний тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь цалин болон ажил олгогчийн НДШ-ийн зардлууд цалингийн хүснэгт болон НДШ-ийн тайлангийн дүнгээс цалингийн зардал 7.2 мянган

төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 35.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан зэрэг алдаа, зөрчлүүд байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7 дахь заалтад заасны дагуу цалин хөлсний тооцоолол, түүнтэй холбоотой үүсэх татвар, шимтгэлийг зөв тооцоолж, хяналт тавьж ажиллах

3. Үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дахин үнэлэгдсэн барилгын цаашид ашиглагдах хугацааг цаашид ашиглах жилээр нь санхүүгийн программд оруулж, элэгдлийг тооцоолоогүйгээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон хуримтлагдсан элэгдлийн дүн 3,666.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдаж байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаал “Аргачлал батлах тухай”-ийн 1 дүгээр хавсралт “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлд дансанд тусгах аргачлал”-ын 5.8 дахь заалт “Хөрөнгийн дахин үнэлгээгээр тодорхойлогдсон цаашид ашиглах хугацаа (Т_{үл})-г дараагийн жилүүдэд элэгдэл тооцоход ашиглана” гэснийг хэрэгжүүлж, 2022 онд барилгын элэгдлийг залруулах

4. Авлага, өглөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Авлага, өглөгийн тооцоог бүрэн нийлж баталгаажуулаагүй, тайланд оны эцэст 249.0 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 12.2.1, 14.4.2, 14.4.3 20.2.5, 20.2.6 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” -ыг хэрэгжүүлж ажиллах

5. Шатахууны хэмжилттэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 3,051.0 мянган төгрөгийн 1,752.5 литр шатахууныг худалдан авч зарцуулсныг санхүүгийн программд холбогдох хэмжих нэгж (литр), нэгжийн өртгөөр хэмжиж бүртгэж, тайлагнаагүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаал “Маягт аргачлал батлах тухай”-ын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал”-ын бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл БМ-1 маягтад нийцүүлэн санхүүгийн тайлагнал, толилуулга, тодруулгад шатахууныг литр, нэгжийн өртгөөр хэмжиж бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга				Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тос	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	7	27,213.8	-	-	-	-	2	20,124.3	5	7,089.5

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК-ийн

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

ЗАХИРАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ

Огноо: 2022.02.25

М.БЯМБАДОРЖ

Огноо: 2/25

Б.БАЙГАЛ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо:

